

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ
ШИНЖЛЭХ УХААНЫ СУРГУУЛЬ
эрдэм шинжилгээний бичиг

Боть XXXX (463)

2016

(85-92)

МОНГОЛ ХЭЛНИЙ ТЭМДЭГ НЭРИЙН УТГЫГ ЭРЧИМЖҮҮЛЭХ
ҮГИЙН ТАЛААРХ ЗАРИМ АЖИГЛАЛТ

Ц. Мөнхдэлгэр *

Хураангуй

Монголын болон монголч эрдэмтдийн бүтээлд дурдагдсан монгол хэлний тэмдэг нэрийн утгыг эрчимжүүлэх үгийн дэлгэрэнгүй бүртгэл гаргаж зарим нэг ажиглалт хийх нь энэхүү бэсрэг өгүүллийн гол зорилго юм. Тэмдэг нэрийн утгыг эрчимжүүлэх үгийн талаарх судалгааны ерөнхий тойм гарган ажиглалт хийж, 1828-2014 оны хооронд хэвлэгдсэн судлаачдийн бүтээлийг судалгаандаа ашигласан болно.

Түлхүүр үг: эрчимжүүлэх үг, давтамж, бүтэц, үүсмэл ба үүсмэл бус

Тэмдэг нэрийн утгыг эрчимжүүлэх үгийн талаарх судалгааны ерөнхий тойм гаргаж үзвэл 1828-2014 оны хооронд хэвлэгдсэн, давхардсан тоогоор нийт 36 судлаачийн бүтээлд нийтдээ 67 үг нь эрчимжүүлэх үг гэсэн нэрээр янз бүрийн давтамжтайгаар бүртгэгдлээ. Энэ бүхнийг тусгай хүснэгтэнд хойно нэгтгэн үзүүлэв. (Нэгдүгээр хүснэгтийг үзнэ үү).

Энэхүү хүснэгтээс үүдэн тэмдэг нэрийн утгыг эрчимжүүлэх үгийн бүгд түүвэрт урьдчилсан байдлаар дараах ажиглалт хийхийг оролдлоо. Үүнд:

Тэмдэг нэрийн утгыг эрчимжүүлэх үг нь бүтцийн хувьд үүсмэл ба үүсмэл бус хоёр зүйл байна.

Үүсмэл бус бүтэцтэй буюу үндэс хэлбэрээрээ тохиолддог эрчимжүүлэх үгийн жишээнд **маш, нэн, тун, чин, час, тас, цэл, тэг, цоо, таг, тэс, шал, пиг, үй, тэн** гэх мэтийн үгийг хамааруулав.

Үүсмэл бус бүтэцтэй эрчимжүүлэх үг нь нийт үгийн дотор тал хувиас нь хавьгүй илүү, хамгийн олон буюу 59,7 хувь байлаа.

Үүсмэл бүтэцтэй буюу цаашид утгат хэсэг болон задардаг эрчимжүүлэх үгийн бүтцийг дараах байдлаар загварчилж болно. Үүнд:

-нэр үг + тай³. Жишээлбэл: ёстой (ёс + той), юутай (юу + тай).

* ШУТИС, Гадаад Хэлний Институт

-нэр үг + гүй. Жишээлбэл: ижилгүй (ижил + гүй), тоймгүй (тойм + гүй), хязгааргүй (хязгаар + гүй), хосгүй (хос + гүй), энгүй (эн + гүй).
 -нэр үг + ын/ийн. Жишээлбэл: туйлын (туйл + ын), адгийн (адаг + ийн), үлэмжийн (үлэмж + ийн), хамгийн (хамаг + ийн).
 -нэр үг + аас⁴. Жишээлбэл: хамгаас (хамаг + аас).
 -нэр үг + аар⁴. Жишээлбэл: үнэхээр (үнэн + ээр).
 -нэр үг + хүү. Жишээлбэл: үнэнхүү (үнэн + хүү).
 -үйл үг + тодотгон холбох нөхцөл + гүй. Жишээлбэл: үзмээргүй (үз + мээр + гүй).
 -үйл үг + шгүй. Жишээлбэл: зүйрлэшгүй (зүйрлэ + шгүй), өгүүлшгүй (өгүүл + шгүй), харшгүй (хар + шгүй).
 -үйл үг + хий. Жишээлбэл: хэтэрхий (хэтэр + хий).
 -үйл үг + уу². Жишээлбэл: давуу (дав + уу), дэндүү (дэнд + үү).

Тэрчлэн хойноо **-ч** хэмээх даган чимэх үг авсан эрчимжүүлэх үг бүртгэгдэв. Жишээлбэл: даан ч, мөн ч гэх мэт. Энэ өвөрмөц задлаг хам бүтэц нь давхар эрчимжүүлсэн буюу лавшруулан эрчимжүүлсэн шинжтэй юм. Мөн тэмдэг нэрийн утгыг эрчимжүүлэх үгийн бүрэлдэхүүнд тогтворгүй -н-тэй үг (пад - падан), төсөөт үг (нэлээн - нэлээд), төлөөний үг (хичнээн) зэрэг хэлзүй, үгийн сангийн өөр өөр хэлбэрүүд хамаарагдсан байна. Бас энэхүү эрчимжүүлэх үгийн түүвэрт цэлдэн, цоодон, пэлдэн гэх мэтийн цэл + дэн, цоо + дон, пэл + дэн гэж угтан чимэх үг + дан⁴ гэсэн загвараар задалж болмоор үг багтсан байна.

Энэхүү хүснэгтийн зүүн дээд өнцгөөс баруун доод өнцөг хүртэл ташуу зураас (диагональ) татан харвал дараах зүйл ажиглагдаж байна. Үүнд:

-Ташуу зураасны зүүн доод тал нь ямар нэгэн тэмдэглээгээр маш сийрэг, бараг цулгуйдуу байхад харин ташуу зураасны баруун дээд тал нь нэлээд шигүү тэмдэглээтэй байна. Энэ нь өмнөх судлаачдынхаа бүтээлд дурдагдсан цөөн хэдэн үгийг дараагийн судлаач нь давтан нэрлэх хандлага тогтвортой хадгалагдахын хамт тухайн судлаач өөрөө шинээр үг нэмж бүртгэх байдал аажмаар нэмэгдэж ирснийг харуулж байна.

-Судлаачдын бүтээлд бүртгэгдэн тэмдэглэгдсэн үгийн тоо 1-ээс 31 хүрсэн байна. Өөрөөр хэлбэл хамгийн эхний судлаач 1828 онд 1 үг, хамгийн сүүлийн судлаач 2014 онд 31 үг тус тус бүртгэн тэмдэглэжээ.

-Ташуу зураасны баруун гар талын дээд хэсэг илүү шигүү тэмдэглээтэй байгаа нь тэр хэсэгт тэмдэглэгдсэн эрчимжүүлэх үг нь өндөр давтамжтай, ингэснээрээ илүү тогтвортой, олон үеийн судлаачдад нэгэнтээ хүлээн зөвшөөрөгдсөн, ерөнхийдөө стандарт байдалтай, төвийн тогтолцооны шинжийг агуулсан байна гэж үзмээр байна.

Тэмдэг нэрийн утгыг эрчимжүүлэх үгийн давтамж

л/д	Давтамжийн тоо (уруудах дарааллаар)	Үгийн тоо	Үгийн жишээ
1	34	1	маш
2	25	1	тун/ тон
3	24	1	үлэмж (-ийн)
4	23	1	нэн
5	17	1	час
6	16	3	тас, шал, пад (-ан)
7	14	3	асар, цэл, таг
8	13	1	пиг
9	12	2	цоо, даан (ч)
10	10	1	чармай
11	9	3	тэс, азай, тэг
12	7	4	цэлдэн, тоймгүй, мөн (ч), энгүй
13	6	2	хязгааргүй, хичнээн
14	5	1	тоо томшгүй
15	4	2	үзмээргүй, хамгийн,
16	3	5	ялангуяа, арай, цал, улам, үнэхээр
17	2	8	чин, бүр, хэт, хамгаас, зүйрлэшгүй, ид, пэлдэн, нэлээн/нэлээд,
18	1	27	аугаа, үтэр, дан, онц, дэн, харшгүй, тан, туйлын, юутай, ашид, адгийн, далай, давуу, хэтэрхий, дэндүү, тэн, огт, ижилгүй, хосгүй, өгүүлшгүй, эн, хачин, цоодон, үй, түг, ёстой, үнэнхүү

Энэхүү хүснэгтээс дараах зүйлийг ажиглан хэлж болох юм. Үүнд:

1. Нийт 36 бүтээл дотор дээд тал нь 36 тохиолдол байх ёстой гэж хийсвэрлэн тооцвол давтамжийн хамгийн өндөр нь 34, харин хамгийн бага нь 1 бөгөөд нийт давтамж нь 34-өөс 1-ийн хооронд хэлбэлзэж байна.
2. Нэг удаа дурдагдсан эрчимжүүлэх үгийн тоо 27 бөгөөд энэ нь нийт эрчимжүүлэх үгийн 40.2 хувь юм.
3. Хамгийн өндөр давтамжийн тал хувь буюу 17-оос дээш давтагдсан эрчимжүүлэх үг 5 бөгөөд эдгээр нь нийт эрчимжүүлэх үгийн 7.4 хувийг эзэлж байна.
4. Давтамж буурах буюу давтамжийн тоо цөөрөх тусам холбогдох үгийн тоо нь олширч

байна. Энэ нь тухайн эрчимжүүлэх үгийн үүрэг - хэрэглээний ачаалалтай холбоотой үзэгдэл байж болох юм. Өөрөөр хэлбэл олон тэмдэг нэрийн өмнө хэрэглэгдэж байгаа эрчимжүүлэх үг нь тоо ширхэгийн хувьд цөөн байдаг бол цөөн тэмдэг нэрийн өмнө тохиолдох эрчимжүүлэх үг нь тооны хувьд олширдог байна. Энэ нь залгамал хэв шинж бүхий монгол хэлний нэг төрлийн элементүүдийн цуваанд ажиглагддаг, үүрэг - хэрэглээгээ тэнцүүлэн зохицуулдаг түгээмэл зүй тогтолтой ижил тогтолцоотой тийм үзэгдэл байж магадгүй гэсэн урьдчилсан таамаглал дэвшүүлэхэд хүргэж байна. Ер нь монгол хэлний нэгэн үгийн доторх бүтээврүүдийн байр¹, нэгэн өгүүлбэр дэх нэмэлт хэлбэрүүдийн дарааллын² талаарх зүй тогтолт хамаарлыг судлаачид урьд өмнө нь нэгэнтээ олж тогтоосон байдаг билээ.

5. Энэхүү давтамжийн дараалал нь олон тэмдэг нэрийн өмнө тохиолддог эрчимжүүлэх үг нь бүтээлч шинжтэй бол цөөн тэмдэг нэрийн өмнө ордог эрчимжүүлэх үг нь бүтээлч бус шинжтэй байдаг гэсэн дүгнэлтэнд бас хүргэж байна.

6. Давтамжийн энэ дарааллыг баримжаалан эрчимжүүлэх үгийг а). бүх тэмдэг нэрэнд холбогдох, б). олон тэмдэг нэрэнд холбогдох, в). цөөн тэмдэг нэрэнд холбогдох, г). ганц тэмдэг нэрэнд холбогдох гэх мэтээр ялган хэлэлцэх боломжтой байна.

7. Тэмдэг нэрийн утгыг эрчимжүүлэх үгийн бүрэлдэхүүнд үүсмэл бус, өөрөөр хэлбэл, дан бүтэцтэй эрчимжүүлэх үг хамгийн олон буюу нийт эрчимжүүлэх үгийн тал хувиас илүү байгаа нь үүрэг-хэрэглээний хувьд хамгийн их ачаалалтай, төвийн тогтолцоог бүрдүүлэх шинжтэй байж болох юм гэж үзмээр байна.

8. Судлаачид тэмдэг нэрийн утгыг эрчимжүүлэх үг гэдэг ерөнхий нэрийн дор янз бүрийн үгийг бүртгэн оруулсан байх бөгөөд эдгээрийг дотор нь нарийвчлан зааглаж, эрчимжүүлэх үгийг жинхэнэ ба жинхэнэ бус гэж урьдчилсан байдлаар ялган үзэж, цаашид нэгбүрчлэн магадлан тогтоох нь зүйтэй гэж үзлээ.

Дүгнэлт

Энэхүү Монголын болон монголч эрдэмтдийн бүтээлд дурдагдсан монгол хэлний тэмдэг нэрийн утгыг эрчимжүүлэх үгийн дэлгэрэнгүй бүртгэл, давтамжиндхийсэн ажиглалтаас үүдэн урьдчилсан байдлаар дараах зүйлийг дүгнэхийг оролдлоо. Үүнд:

- Бүтцийн хувьд тэмдэг нэрийн утгыг эрчимжүүлэх үг нь үүсмэл ба үүсмэл бус хоёр зүйл байна.
- Давтамжийн хувьд давтамж буурах буюу давтамжийн тоо цөөрөх тусам холбогдох үгийн тоо нь олширч байна.
- Давтамжийн дараалал нь олон тэмдэг нэрийн өмнө тохиолддог эрчимжүүлэх үг нь бүтээлч шинжтэй бол цөөн тэмдэг нэрийн өмнө ордог эрчимжүүлэх үг нь бүтээлч

¹“Үгийн бүтцэд байгаа бүтээврүүд урагшаа цөөн төрлийн бүтээвэртэй харьцвал хойш олон төрлийн бүтээвэртэй шууд харьцах ба урагшаа олон төрлийн бүтээвэртэй харьцвал хойшоо цөөн төрлийн бүтээвэртэй шууд харьцаж үгийн бүтцэд эзлэх байрлалаа тэнцүүлэн зохицуулж байдаг шинжтэй гэж үзэж болмоор байна” (Ц. Өнөрбаян 1982:52).

² “Тэрчлэн цаг заах төлөвийн нөхцөл нь өөрөө тооны хувьд цөөн тул хойно нь олон нэмэлт хэлбэр ордог; захирах хүсэх төлөвийн нөхцөл нь тоогоор олон тул хойно нь цөөн нэмэлт хэлбэр ордог гэж үзэж болмоор байна. Ингэснээр тухайн өгүүлэмжийн хүрээнд илэрхийлэх цаг - бие - баймжийн утгазүйн ачааллаа тэнцүүлэн зохицуулдаг зүй тогтолтой ажээ. Энэ бол залгамал хэлний бүтцийн хэв шинжтэй холбоотой зүйл юм” (Ю. Мөнх-Амгалан 1998:295).

бус шинжтэй байдаг гэсэн дүгнэлтэнд бас хүргэж байна.

- Давтамжийн дарааллыг баримжаалан эрчимжүүлэх үгийг а). бүх тэмдэг нэрэнд холбогдох, б). олон тэмдэг нэрэнд холбогдох, в). цөөн тэмдэг нэрэнд холбогдох, г). ганц тэмдэг нэрэнд холбогдох гэх мэтээр ялган хэлэлцэх боломжтой байна.
- Тэмдэг нэрийн утгыг үүрэг-хэрэглээний хувьд хамгийн их ачаалалтай, төвийн тогтолцоог бүрдүүлэх шинжтэй байж болох юм гэж үзмээр байна.
- Тэмдэг нэрийн утгыг эрчимжүүлэх үгсийг дотор нь нарийвчлан зааглаж, жинхэнэ ба жинхэнэ бус гэж урьдчилсан байдлаар ялган үзэж, цаашид нэг бүрчлэн магадлан тогтоох нь зүйтэй гэж үзлээ.

Нэгдүгээр хүснэгт

Тэмдэг нэрийн утгыг эрчимжүүлэх үгийн бүгд түүвэр

[illegible]

НОМ ЗҮЙ

- Агваандандар. (1828) Монгол үсгийн ёсыг сайтар номлосон хэлний чимэг хэмээгдэх оршивой. - Монгол хэл шинжлэлийн дурсгал. Кирилл бичигт буулгасан В.Энхболд, П.Одончимэг. Уб., 1997. 30-37 дахь тал.
- Аюушжав, П. (2005) Тэмдэг нэрийн харьцуулсан зэргийн тухайд. - “Монгол хэл шинжлэл”. Том VIII (XXX). 70-75 дахь тал.
- Базаррагчаа, М. (1990) Монгол хэлний тэмдэг нэрийн харьцуулах ай. - “Эрдэм шинжилгээний бичиг”. МУИС. № 4 (102). 319-328 дахь тал.
- Базаррагчаа, М. (2005) Монгол хэлний өгүүлбэр судлал. Уб.
- Балдан, Л. (1987) Тэмдэг нэр. - Орчин цагийн монгол хэлний үгзүйн байгуулал. Тэргүүн дэвтэр. ШУА, ХЗХ, Уб.
- Бертагаев, Т.А. (1969) Морфологическая структура слова в монгольских языках. М.
- Бобровников, Александр. (1835) Грамматика монгольского языка. СПб.
- Болд, Л. (1996) Орчин цагийн монгол хэлний тэмдэг нэрийн ангилал, зэргийн тухай асуудалд. - “Монгол хэл шинжлэл”. Том II (XXIV). 23-36 дахь тал.
- Бямбасан, П. (1966 а) Орчин цагийн монгол хэлний тэмдгийн нэрийн харьцуулсан зэргийн тухай асуудалд. - “Заах арга-эрдэм шинжилгээний бичиг”. УБДС. 3-15 дахь тал.
- Бямбасан, П. (1966 б) Тэмдгийн нэр. - Орчин цагийн монгол хэл зүй. ШУА, ХЗХ, Уб.
- Бямбасан, П. (1975) Орчин цагийн монгол хэлний үгийн бүтэц, нэр үгсийн аймаг. Уб.
- Бямбасан, П. (1997) Үгсийн аймаг, нэр үг, туслах үг. - Орчин цагийн монгол хэл. ШУА, ХЗХ, Уб.
- Бямбадорж, Б. (2006) Орчин цагийн монгол хэлний хэлбэр судлал. Уб.
- Галсан, С. (1975) Сопоставительная грамматика русского и монгольского языков. (Фонетика и морфология). Часть I. У-Б.
- Гүн-Үйлс, Д. (2007) Англи Монгол зэрэгцүүлсэн хэл зүй. Уб.
- Жанчивдорж, Ц. (1961) Орчин цагийн монгол хэлний тэмдгийн нэрийн тухай. - “Эрдэм шинжилгээ-заах аргын бичиг”. Монгол хэл бичиг-утга зохиолын бүлэг. I. УБДС. 42-67 дахь тал.
- Ковалевский, О. М. (1835) Краткая грамматика монгольского книжного языка. Казань.
- Лувсанчойнхор. (1891-1928 оны хооронд) Монгол үсгийн гол ёсыг тодотгогч толь хэмээх бичиг. - Монгол хэл шинжлэлийн дурсгал. Кирилл бичигт буулгасан В.Энхболд, П.Одончимэг. Уб., 1997. 20-29 дэх тал.
- Лувсанвандан, Ш., Дэмчигдорж, Б. (1951) Монгол хэлний зүй. Нэгдүгээр дэвтэр. Авиа ба үгийн зүй. - Шадавын Лувсанвандан Бүтээлийн чуулган. II боть. Эрхлэн хэвлүүлсэн Ж.Баянсан, Д.Заяабаатар. Уб., 2010.
- Лувсанвандан, Ш. (1961) Орчин цагийн монгол хэл. - Шадавын Лувсанвандан Бүтээлийн чуулган. IV боть. Эрхлэн хэвлүүлсэн Ж.Баянсан, Д.Заяабаатар. Уб., 2010.
- Лхамсүрэн. (1903) Монгол үсгийн ёсыг тодорхойлон гаргасан алтан толь хэмээгдэх оршивой. - Монгол хэл шинжлэлийн дурсгал. Кирилл бичигт буулгасан В.Энхболд, П.Одончимэг. Уб., 1997. 38-47 дахь тал.
- Лхагва, Л. (1976) Хэлзүйн тайлбар. - Монгол хэл сурах бичиг. (Гадаадынханд зориулав). Уб.

- Мишиг, Л. (1978) Орчин үеийн монгол бичгийн хэлний дадлагын хэл зүй. Уб.
- Мөнх-Амгалан, Ю. (1998) Орчин цагийн монгол хэлний баймжийн ай. Нэмэн засварласан хоёрдахь хэвлэл. Уб.
- Мөнх-Амгалан, Ю., Кан Шин. (2014) Орчин цагийн монгол хэлний бүтээвэр судлал. Анхдугаар хэвлэл. Уб.
- Орлов, А. (1878), Грамматикамонголо-бурятского разговорного языка. Казань.
- Орловская, М.Н. (1961), Имена существительные и прилагательные в современном монгольском языке. Изд. Восточной литературы. М.
- Өнөрбаян, Ц. (1982) Орчин цагийн монгол хэлний нэр үгийн аймгаас жинхэнэ нэр бүтэх тухай. -“Эрдэм шинжилгээний бүтээл”. УБДС. 42-52 дахь тал.
- Өнөрбаян, Ц. (2004) Орчин цагийн монгол хэлний үг зүй. Уб.
- Санжеев, Г.Д. (1959) Современный монгольский язык. М.
- Тодаева, Б.Х. (1951) Грамматика современного монгольского языка. М.
- Цэдэндамба, Ц. (1974) Очерки по сопоставительной грамматике русского и монгольского языков. У-Б.
- Isidorji. (1931) Mongoliin sine ysegiin zaabar (tursilga). Ulayanbayatur.
- Čenggeltei. (1999) Odo üy-e-yin mongyol kelen-ü jüi. (Nemen jasaysan keblel). Öbör mongyol-un arad-un keblel-ün qoriy-a. Kökeqota:Jan jiya. 2972 tal-a.
- Kullmann, Rita., Tserenpil, D. (1996), *Mongolian Grammar*, Hong Kong, 447 pp. (second edition 2001, Hong Kong; third revised edition 2005, UB).
- Poppe, N.N. (1951) *Khalkha-mongolische Grammatik*. Wiesbaden: Franz Steiner Verlag.
- Poppe, N.N. (1954) *Grammar of Written Mongolian*. Wiesbaden.
- Schmidt, I. J. (1831) *Grammatik der Mongolischen Sprache*. St. – Petersburg.

ABSTRACT

Augmentative words, such as ulemj- “much, many, considerable, greatly, extensively”, mas - “very, extremely, very much”, eng - “extremely, really, most”, asar - asuru “very, very much, greatly, extremely”, cing - “firmly, truthfully, sincerely”, “white-haired”, ucuken - “not many, not much”, etc are placed in front of adjectives to add to their meaning. Often they make the meaning of the adjective stronger, or more intense. For this reason, these words are called intensifiers.

This paper attempts to make a list and to analyze augmentative meanings of adjectives, used in studies and research, which are published between 1828-2015, of the scientists from Russian and Mongolian.

A working definition of augmentative words will be established on the basis of standard Mongolian grammar. Thereafter a lexical analysis of different intensifiers will be conducted to identify the different augmentative words used. The results will also be analysis based on list and the frequency of augmentative words.